

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 8 ДУГААР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

“Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоол, “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 09 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 04 дүгээр албан даалгаврыг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Албан даалгаврын хавсралтаар аймаг, сумын нөөцөд бэлтгэн нийлүүлэх өвс, тэжээлийн хэмжээг баталж, 19 сум, агентлаг, төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлсэн.

Аймгийн аюулгүйн нөөцөд 35 агентлаг, төрийн өмчит аж ахуйн нэгж 113 тн өвс, сумын аюулгүйн нөөцөд 19 сумын Засаг даргын тамгын газар 1520 тн өвс, 570 тн тэжээл, нийт 1670 тн өвс, 620 тн тэжээл, малчдын түвшинд 80 мянган тн өвс, 1300 тн тэжээл тус тус бэлтгэхээр төлөвлөсөн.

Хөдөө аж ахуйн салбарын болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл, цаг үеийн нөхцөл байдалтай танилцаж, зөвлөмж чиглэл өгөх 6 ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, аймгийн Засаг дарга 8 дугаар сарын 24-ний өдөр ажлын хэсгийн ахлагч нартай уулзаж чиглэл өгсөн.

Ажлын хэсгүүд 2022 оны 8 дугаар сарын 29-нөөс 31-ний өдрүүдэд хуваарийн дагуу 19 сум, байгууллагуудад ажиллаж, өвөлжилтийн бэлтгэл хангах ажилтай танилцах, цаг үеийн ажлаар зөвлөмж чиглэл өгөх ажил үргэлжилж байна.

Улсын Их Хурлын даргаар ахлуулсан Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, эрдэмтэн судлаачид оролцсон, Орхоны хөндийд хангайн бүсийн тулгуур төв шинэ Хархорум хотын байршлын бүс бий болгох асуудлыг судлах, санал, дүгнэлт, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж танилцуулах зорилго бүхий хамтарсан ажлын хэсэг Архангай, Өвөрхангай аймаг буюу шинэ Хархорум хот байгуулахаар судалж буй Орхоны хөндийд 2022 оны 8 дугаар сарын 01-нээс 05-ны өдрүүдэд ажиллаж түүх, соёлын дурсгалт газар нутаг, үнэт олдворуудтай газар дээр нь танилцсан байна.

2004, 2010, 2021 онуудад хот байгуулахад тохиромжтой газар нутгийн судалгааг Архангай аймгийн Батцэнгэл, Өгийнуур сумдын нутагт байрлах Тоглохын тал газрын 40,446.3 га талбай, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутгийн тусгай хамгаалалттай газрын хилээс зүүн тийш Онгоцон хөндий, Гурвалжин уул, Их номт овоо хүртэлх 41431.5 га талбайг хамруулан хийсэн бөгөөд судалгаагаар нийслэлийн баримжаатай шинэ хот байгуулахад талбай, хөрс, гүний усны нөөцийн хувьд Архангай аймгийн Өгийнуур сумын Өгийнуурын 168,642.4 га талбай хамгийн тохиромжтой гэсэн дүгнэлт гарсан байна.

Засаг захиргааны нэгжийн хувьд энэ бүс нутагт Орхоны хөндийд орших Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Хотонт, Хашаат сумд, Булган аймгийн Могод, Гурванбулаг, Сайхан сумд, Өвөрхангай аймгийн Хархорин сум, нийт 3 аймгийн 8 сум 46 багийн нутаг дэвсгэр орж байна.

“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагын “Хүмүүнлэгийн яаралтай тусламжийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2022 онд үерийн аюулд нэрвэгдэж орон гэргүй болсон Архангай аймгийн Хангай, Чулуут, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Өндөр-Улаан, Цэцэрлэг сумдын 15 өрхөд иж бүрэн гэр хандивласныг аймгийн хөрөнгөөр татан авч иргэдэд гардуулж өгсөн. Архангай аймаг хөдөө орон нутгаас анх удаа энэ хөтөлбөрт сонгогдсон аймаг болсон.

Засгийн газрын 2020 оны 09, 2021 оны 278 дугаар тогтоолуудын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогыг зохион байгуулах аймгийн комисс томилогдож, 19 сумын 171 орон нутгийн өмчит байгууллагад

үзлэг тооллогын ажлыг явуулсан, үзлэг тооллогын дүнг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлэхээр боловсруулж байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсвийн орлого

2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 1,765,024,932.5 төгрөг төвлөрүүлэхээс 1,744,536,799.1 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 98.8 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 1,443,864,400.0 төгрөг төвлөрүүлэхээс 1,618,617,597.7 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 112.1 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 8664519.8 төгрөг төвлөрүүлэхээс 7826621.1 төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 90.3 хувийн тус тус биелэлттэй байна.

Тендер, худалдан авалт

2022 онд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 126,751,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 91 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан.

Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр хэрэгжүүлэх 116383.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн. Эрх шилжиж ирсэн 27 төсөл арга хэмжээнээс төсвийн тодотголоор 700.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээ хасагдсан. 400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээний тендер 2 удаа зарлагдсан, шаардлага хангасан тендер ирээгүй тул захиалагч техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулан тендерийг дахин зарлаж 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр тендерийг нээсэн, үнэлгээ хийгдэж байна.

2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 115,283,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан.

2022 оны 8 дугаар сард улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга угсралт болон их засварын 8 ажилд барилга захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэсэн.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 81,527,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 55 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3,704,9 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгөөр хийгдэх их засвараар 1,100,0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдсанаас 2022 оны эхний 8 сарын байдлаар улсын төсвийн хөрөнгийн 9,050,7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 653,7 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын 750,5 сая төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн байна.

Цахим шилжилт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цахим Архангай” төрийн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Цахим аймаг” хөтөлбөрийн төслийг боловсруулж, хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Ай Си Ти групп” ХХК-ийг шалгаруулж, гүйцэтгэгчтэй 1,4 тэрбум төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний цахим шийдэл, Сургуулийн сургалтын удирдлагын цахим шийдэл, Хөрөнгө оруулалтын удирдлагын цахим шийдэл, Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын цахим шийдэл, Аймгийн орон зайн мэдээллийн систем, Тээврийн хэрэгслийн хяналтын цахим шийдэл, Автомат шалган

нэвтрүүлэх шийдэл, Аймгийн иргэдэд зориулсан нэгдсэн гар утасны аппликейшн зэрэг системүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Орон нутгийн оператор ажилтнуудаар дамжуулан улсын хэмжээнд 210 гаруй төрийн үйлчилгээг цахимаар үзүүлж, нийт ХУР, ДАН системээр иргэдэд 61 байгууллагын 660 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байгаа бөгөөд Архангай аймгийн нутгийн захиргааны 13 байгууллагын 51 үйлчилгээ цахимжиж, "e-mongolia" системд нэвтэрсэн.

Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх төслийн хүрээнд Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан, Ихтамир сумдад 20 м өндөртэй харилцаа холбооны цамхаг угсарч суурилуулах, Цэнхэр, Хашаат сумдад үйлчилгээний нэгдсэн төвийн шинэ барилга барих ажлууд хийгдэж дууссан 8, 9 дүгээр сард ашиглалтад орно.

Мөн хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ хүргэх төслийн хүрээнд Өндөр-Улаан сумын Азарга баг, Ихтамир сумын Бугат, Хөхнуур баг, Тариат сумын Алтаад багуудад холбогдох дэд бүтцийн ажлууд хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт

Аймгийн хэмжээнд 2022 оны 8 дугаар сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 9 удаа гарснаас, объектын гал түймэр 2, усны ослын дуудлага 1, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин 1, үер, усны мэдээлэл 2, үйлдвэрийн осол 1, зам тээврийн осол 1, хүний гоц халдварт /ковид-19/ өвчин 1 тус тус гарч ОБГ-ын алба хаагчид 17 хүний амь нас, 65 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 7 сарын байдлаар нийт 1598 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 593, зөрчлийн шинжтэй 1005 гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 416 буюу 26.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны эхний 7 сарын байдлаар аймгийн хэмжээнд 228 холбогдогчтой 901.1 сая төгрөгийн хохиролтой 288 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 87 буюу 30.2 хувь, холбогдогч нь 76 буюу 33.6 хувиар өссөн байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 81 буюу 28.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 102 буюу 35.4 хувийг хулгайлах төрлийн гэмт хэрэг, 40 буюу 13.8 хувийг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, 16 буюу 5.5 хувь нь авто ослын гэмт хэрэг, 21 буюу 7.2 хувийг залилах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Шүүхийн шинжилгээний алба 2022 оны 8 дугаар сард шүүх эмнэлгийн шинжилгээ 57, тусгай шинжилгээ 42-г хийсэн байна.

2022 оны 8 дугаар сард Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2957011.2 төгрөгийн мөнгөн дүн бүхий 475 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 43, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 22.7 байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар дараах бүртгэлийн хийж гүйцэтгэсэн байна.

Төрсний бүртгэл – 148

Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 4

Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 10

Гэрлэсний бүртгэл - 15

Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл- 4

Үрчилсний бүртгэл - 1

Нас барсны бүртгэл - 48

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл –8

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 18

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл –2

Худалдах худалдан авах гэрээ – 58

Бэлэглэлийн гэрээ – 7

Барьцааны эрхийн бүртгэл – 169

Өв залгамжлал – 10

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 6

Лавлагаа – 0

Бусад эрхийн бүртгэл – 12

Хууль хяналтын байгууллагад нийт 32 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрхи бүртгэлүүдийг хийж үйлчилгээний хөлс 2523514 төгрөг, тэмдэгтийн хураамжид 80499 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 11316000 төгрөгийг тус тус улсыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Шинээр бүртгүүлсэн – 5

Өөрчлөлт – 10

Тамганы хяналтын дугаар олгосон –5 бүртгэл хийсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

2022 оны 5 дугаар сарын 24-нөөс 27-ны өдрүүдэд улс даяар зохион байгуулсан төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр Архангай аймаг улсын хэмжээнд гуравдугаар байранд шалгарсан байна.

Архангай аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 30 сургууль, хүүхдийн 36 цэцэрлэг 1024 багштайгаар 19000 гаруй хүүхдийг хүлээн авах бэлтгэл ажлыг хангасан, аймгийн хэмжээнд дутагдалтай байгаа багшийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, мэргэжлийн багшийн хангалт 95% болсон.

Аймгийн багш нарын бага хурлыг 2022 оны 8 дугаар сарын 27-ны өдөр "Боловсролын цахим үзэсгэлэн" нэртэйгээр зохион байгууллаа. Цахим үзэсгэлэнд 2021-2022 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын тайланг цахим болон цаасан хэлбэрээр нээлттэй танилцуулж 2022-2023 оны хичээлийн жилийн зорилго, зорилго, анхаарах асуудлаа зөвлөлдлөө.

Улсын төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн 30 ерөнхий боловсролын сургууль, 33 хүүхдийн цэцэрлэгт 100 зөөврийн компьютер, 25 ухаалаг самбарын хангалт хийсэн.

2022 онд боловсролын салбарт улсын болон орон нутгийн төсвийн 41.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 26 барилга, өргөтгөл, их засварын ажил, үүнд багшийн хөгжил, судалгааны арга зүйн төв-1, сургууль-8, дотуур байр-1, цэцэрлэг-7 нийт 17 барилгыг улсын төсвийн 40,4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр шинээр барих, сургууль- 3, спорт заал-4, цэцэрлэг-1 нийт 8 барилгад улсын төсвийн 200,0 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 902,0 сая, нийт 1,1 тэрбум төгрөгийн их засварын ажлыг тус тус гүйцэтгэхээр төлөвлөснөөс 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар барилга, засварын ажлын гүйцэтгэл дунджаар 55 хувьтай байна.

Соёл, урлаг

Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2022 оны 8 дугаар сарын 12-наас 14-ний өдрүүдэд "Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар"-т зохион байгуулсан "Нүүдэлчин Монгол-2022" соёлын биет бус өвийн их наадамд Архангай аймгийн төлөөлөл оролцож аймгийн өвлөн уламжлагч нарын зан үйлийн үзүүлбэр, язгуур урлагийн тоглолт, гар урлалын үзэсгэлэн, соёлын биет бус өвийг таниулан сурталчилсан.

Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан аймгийн Хөгжимт драмын театр Монголын хүүхэлдэйн театрт хамтран Ц.Гауфын зохиол "Том хамарт одой" хүүхэлдэйн жүжгийг тайзнаа тавьж хүүхэд багачуудад хүргэхээр бэлтгэж байна.

Эрүүл мэнд

2022 оны 5 дугаар сарын 01-нээс улсын хэмжээнд эхэлсэн хүн амыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд Архангай аймагт 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 18-30 насны 731, 31-45 насны 490, 46-60 насны 285, 61-ээс дээш насны 43, нийт 1549 иргэн үзлэгт хамрагдсанаас эрүүл илэрсэн иргэн 544, эрсдэлтэй илэрсэн иргэн 111, өвчтэй илэрсэн иргэн 894 байна.

0-5 насны 1624, 6-17 насны 3287 нийт 4911 хүүхэд үзлэгт хамрагдсанаас эрүүл илэрсэн хүүхэд 2435, эрсдэлтэй илэрсэн хүүхэд 241, өвчтэй илэрсэн хүүхэд 2235 байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал

/2022.08.28-ны байдлаар/

Батлагдсан тохиолдол:

Нийт батлагдсан тохиолдол (2021-2022 он)– 17809

Үүнээс: 2022 онд – 4946

Сүүлийн 7 хоногт батлагдсан тохиолдол – 32 (8-р сарын 22-28)

Нас баралт:

Нийт нас баралт – 42

Үүнээс: 2021 онд – 39

2022 онд - 3

Түргэвчилсэн шинжилгээ:

Нийт хийсэн түргэвчилсэн шинжилгээ (2021-2022 он) - 52623

Үүнээс 2022 онд - 9466

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 119 (8-р сарын 22-28)

Үүнээс эерэг – 26

ПСР шинжилгээ:

Нийт хийсэн ПСР шинжилгээ (2021-2022 он) - 89318

Үүнээс 2022 онд - 11806

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ – 48 (8-р сарын 22-28)

Үүнээс эерэг –5

Вакцинжуулалт:

1-р тунд 60782 хүн буюу 87,1 % (12-оос дээш нас)

2-р тунд 57566 хүн буюу 82,2 % (12-оос дээш нас)

3-р тунд 27236 хүн буюу 48,9 % (18-аас дээш нас)

4-р тунд 2451 хүн буюу 4,9 % (18-аас дээш нас)

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2022 оны 8 дугаар сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 1006 иргэн бүртгэлтэй байгаагаас 444 эмэгтэй. Шинэ ажлын байр 452, үүнээс байнгын ажлын байр 259, улирлын ажлын байр 12, түр ажлын байр 181 байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Аймгийн 19 сумын 101 багийн 8207 хот айлд 15.5 мянган малчин, мал бүхий өрхийн 3.9 мянган малчин, нийт 19.4 мянган өрхийн 7.6 сая толгой малыг өвөлжүүлэх хаваржих төлөвтэй байна.

Мал сүргийг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 1.4 сая толгой малыг зах зээлд нийлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Аймаг нийт 5.5 сая га бэлчээртэй, үүнээс 3.7 сая га бэлчээрийн талбайтай, 100 га-д 62 толгой мал хонин толгойд шилжүүлснээр тохиромжтой байдаг бол 2022 оны 8 дугаар сарын байдлаар 100 га-д 503 толгой мал хонин толгойд шилжүүлснээр оногдож, бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Малын тоо толгойн татварын орлогоор 2 суманд 5 цооног, 7 худгийн засварын ажил, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 16 суманд 19 худаг гаргахаас 2021 онд 13, 2022 онд 6 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж ашиглалтад орсон.

Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулдаг үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг малын тоо толгойн татварын орлогоор 2022 оны 4-ээс 6 дугаар сард Хангай, Цахир, Өгийнуур сумдын нийт 10 багийн 7800 га талбайд 104 малчны оролцоотойгоор 81 хувийн техник үр дүнтэйгээр, Хайрхан сумын 5 га талбайд энгийн механик, биологийн аргаар 16 малчны оролцоотойгоор 80 хувийн үр дүнтэйгээр тус тус зохион байгууллаа.

Архангай аймгийн Ихтамир сумын Бугат багийн Хүнүйн гол гэх газар малчин Л-ээс мал амьтны гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг бүхий дуудлага ирсний дагуу 2022 оны 7 дугаар сарын 23-ны өдөр дээж авч, дээжийг 7 дугаар сарын 28-ны өдөр УМЭАЦТЛ-т илгээж, 8 дугаар сарын 01-ний өдөр шинжилгээний хариу “**эерэг**” буюу өвчтэй гэж батлагдсан.

Шинжилгээний хариуг үндэслэн сумын Засаг даргын захирамж гарч Хүнүйн гол, Шивээтийг голомтын бүсээр тогтоон, суурин-3 пост, хөдөлгөөнт эргүүл-1, нийт 30 албан хаагч, 6 техник хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байна. Голомтын болон сэжигтэй бүсийн 26 өрхөд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг тогтмол өгч 18.200 м² хашаа хороонд ариутгал, халдваргүйтгэл хийсэн. Шүлхий өвчний дуудлага 8 дугаар сарын 30-ны байдлаар нэмж ирээгүй байна.

Газар тариалан

Архангай аймаг 2022 онд аймгийн хэмжээнд 8265 га-д үр тариа, үүнээс 7965 га-д улаанбуудай, 4100 га-д малын тэжээл, 600 га-д тосны ургамал, 275 га-д төмс, 166 га-д хүнсний ногоо, 80 га-д жимс жимсгэнэ, нийтдээ 13486 га-д тариалалт хийж 7600 га-д уринш боловсруулахаар төлөвлөснөөс улаанбуудай 10453 га-д, арвай 70 га-д, хошуу будаа 340 га-д, тосны ургамал 1225 га-д, малын тэжээл 2440 га-д, хүнсний ногоо 126 га-д, төмс 263 га-д, жимс, жимсгэнэ 84 га-д, нийт 15001 га талбайд тариалалт хийсэн.

Улаанбуудай тариалсан 7 сумын 41 иргэн аж ахуй нэгж, төмс тариалсан 17 сумын 234 иргэн, аж ахуй нэгж, хүнсний ногоо тариалсан 18 сумын 274 иргэн, аж ахуй нэгж, нийт 419 иргэн, аж ахуй нэгжийн бүртгэлийг шатахууны үнийн хөнгөлөлтөд хамруулахаар дээд шатны байгууллагад судалгааг хүргүүлсэн.

Хаврын тариалалтад трактор 346, үр тариа үрлэгч 31, хүнсний ногооны үрлэгч 7, анжис 26, борной 39, бул 11, өргөн холбоо 10, сэндэчлүүр 7, бүх төрлийн сийрүүлэгч 13, хор цацагч 8, бордоо, бууц цацагч 3, 1-25 га-г услах хүчин чадал бүхий услах бороожуулагч 3, төмс, хүнсний ногооны бага оврын иж бүрдэл трактор 3, нийт 507 техник хэрэгсэл ажилласан. 2022 оны намрын ургац хураалтад ажиллах хүн хүчний захиалгад 4 сумын 187 хүний захиалга ирсэн байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

Ногоон байгууламж, мод тарих

Архангай аймаг нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2030 оныг хүртэлх хугацаанд 20 сая мод тарьж ургуулах төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/713 дугаар захирамжаар байгуулан аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 19 сумын хэмжээнд 317716 ширхэг мод, бут сөөгийг үрээр болон тарьц суулгацаар тарьж усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгэж байна. Энэ жилийн мод тарих ажлын хүрээнд төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын төвийн хашаа, хамгаалалттай сад, цэцэрлэгт хүрээлэнг засаж сэлбэн сайжруулж мод тарих чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгч хамтран ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, элсний нүүлтийг зогсоох, иргэдийн ажиллаж амьдарч буй орчныг ногоон байгууламжтай болгох зорилгоор нэг иргэн нэг мод уриалгыг өрнүүлж иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж байна. Мөн ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу ойн мэргэжлийн байгууллагууд бэлтгэсэн модныхоо тоо хэмжээнээс хамааруулан ойжуулалтын ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна.

2022 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 468.0 мянган ширхэг модыг тарихаар төлөвлөснөөс ажлын гүйцэтгэл 67.8 хувьтай байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь зөвхөн мод тарихаас гадна байгалийн ойн санг арчилж хамгаалах, сайн чанарын ой бий болгох, ойн талбай, нөөцийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Байгалийн ойн сэргэн ургалтад муугаар нөлөөлж буй хүчин зүйлүүдийн нэг болох болц гүйцээгүй үед хуш модны самрын нөөцийг хууль бусаар бэлтгэх асуудалд анхаарч хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагууд ойн дагалт баялгийг хамгаалах, зүй зохистой бэлтгэж ашиглах чиглэлээр иргэдийг мэдээллээр хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалт хийх ажлын хэсэг Цэнхэр, Ихтамир, Батцэнгэл, Булган, Тариат, Жаргалант сумдад ажиллаж байна.

Архангай аймгийн хэмжээнд 12 сумын 13102 га талбайд хуш мод ургадаг бөгөөд хүний буруутай үйл ажиллагааны улмаас гэмтэж, их үрийн жилийн давтамж уртасч, нөөцийн хэмжээ багасаж байна.

Хог хаягдлын менежмент

Аялал жуулчлын бүс нутаг болох Өгийнуур, Тэрхийн цагаан нуур, Цэнхэрийн халуун рашаан, Тамирын голын эрэг, Тайхар чулуу орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажил тухай бүрт хийгдэж, 2022 оны 8 дугаар сарын байдлаар 8.7 тонн хог хаягдлыг хог хаягдлын цэгт хүргэж, ажлын гүйцэтгэл 60 хувьтай, хог цэвэрлэгээний ажил үргэлжилж байна.

Чулуут сумын хогийн цэгийг гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг “Газрын гагнаас” ХХК гүйцэтгэж ажлын гүйцэтгэл 80 хувь, Хангай сумын хогийн цэгийн хэмжээг бууруулах, хог хаягдлыг түрж дарж булшлах ажлын гүйцэтгэл 50 хувьтай явагдаж байна, Хотонт, Хангай сумд хогийн цэгийг камержуулсан.

“Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтийг хангах нь” төслийн 45 сая, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 45 сая, нийт 90 сая төгрөгний санхүүжилтээр Хайрхан суманд “Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтын санал санаачилгыг дэмжих нь төсөл” хэрэгжиж ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна.

Энэхүү төслийн хүрээнд ангилдаг хогийн сав 6 ширхэг, хоёрдогч түүхий эд авах автомат машин 1 ширхэг, албан байгууллагын ангилдаг хогийн сав 6 ширхэг, хог шахагч машин 1 ширхэг, хог шатаах зуух 1 ширхэг, 10 айлын хашааны тохижилт жорлон, хогийн савыг шийдвэрлэж хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэнэ.

Байгаль хамгаалал

Аймгийн Зоонозын өвчин судлалын төв, эрдэмтэн судлаачидтай хамтран Архангай аймгийн Ихтамир сумын Хөхнуурт “Уур амьсгалын өөрчлөлт тарваган тахлын байгалийн голомтын биологийн төрөл зүйл, хөдлөл зүй, хүн амын эрсдэлт хүчин зүйлд үзүүлэх нөлөө” сэдэвт хамтарсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2015 оноос хойш аймгийн хэмжээнд тогтмол 350-аас дээш цэг дээр бэлчээрийн даацыг тодорхойлох фотомониторингийн судалгааны ажлыг зохион байгуулж, тухайн жилд ургасан ургамлын төрөл зүйл, ургацын хэмжээ, даац, хөрсний идэгдэц, тухайн бэлчээр ашиглалтын хэсгийн бэлчээрийн даац, малчдын бэлдэх хадлангийн нөөцийг тодорхойлдог бөгөөд 2022 онд тус судалгааны ажлыг 19 сумын 355 цэгт хийсэн.

“Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн хүрээнд ШУА-ын Биологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид Хустайн нурууны БЦГ-аас 40

толгой тарвага барьж, төсөл хэрэгжих зорилтот нутгийн нэг болох Архангай аймгийн Батцэнгэл сумын Улаанчулуу баг, Хайрхан сумын Жарантай багийн нутагт сэргээн нутагшуулах ажлыг зохион байгууллаа.

Барилга, дэд бүтэц

Архангай аймгийн төв Эрдэнэбулган сумын доторх хатуу хучилттай 2100 м² авто замын засвар, арчлалтын ажлыг “ЛМДШ” ХХК орон нутгийн авто замын сангийн 239,0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж байгаа бөгөөд 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 65 хувьтай байна.

2022 онд аймгийн хэмжээнд дараах орон сууц баригдаж байна. Үүнд:

д/д	Захиалагч иргэн, аж ахуйн нэгж	Гүйцэтгэгч аж ахуйн нэгж	Давхрын тоо	Айлын тоо	Барилгын ажлын гүйцэтгэл
1	Иргэн Сүхээ	“Тамир таун” ХХК	5	15	95%
2	Иргэн Б.Үүрцайх	“Цагаан Сүмбэр” ХХК	5	50	80%
3	Иргэн Ж.Нэргүй	“Гурван Тамир” ХХК	5	15	30%
4	Иргэн Б.Бадрал	“Гэрэгэ” ХХК	5	17	75%
5	Иргэн Н.Баянмөнх	“Сайхан тэрх” ХХК	5	15	80%
6	Иргэн Бямбаа	“Идэрживаа” ХХК	6	60	95%
7	Иргэн Н.Номин	“Тайгер дизайн” ХХК	4	12	30%
8	Иргэн Манлай	“Марч контсракшн” ХХК	6	42	90%
9	Иргэн Манлай	“Марч контсракшн” ХХК	7	49	40%
10	Иргэн Д.Батбаяр	“Класик булдинг” ХХК	9	128	0%
11	Иргэн Н.Баянмөнх	“Сайхан тэрх” ХХК	9	54	30%
12	Иргэн Нямдорж		9	-	0%
13	Иргэн Д.Чулуунбаатар	“Эсгэл” ХХК	5	25	60%
14	Иргэн Б.Шинэбаатар		5	15	20%
15	Иргэн Бямбаа	“Идэрживаа” ХХК	5	40	40%
16	Иргэн Бямбаа	“Өлзий тээл” ХХК	5	40	40%

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----